



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.10 № 68
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН УС ЦАГ УУР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА С.ОТГОНБААТАР ТАНАА

**2025 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүвэрт хамруулан, баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар нийт 1,037.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитаар илрүүлсэн зөрчлийг асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 1,037.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Зөвлөмж:

Илрүүлэлт 1: Шуудан холбооны зардлын 1,037.9 мянган төгрөгөөр түрээсийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтын зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шуудан холбооны зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр

612505222

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА